

Улс төрийн “патронаж” хэмээх нэр томьёог хэвшүүлэн хэрэглэх тухайд

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Цэрэндашийн БАТБОЛД*

*Монгол Улс, Улаанбаатар, Монгол Улсын Их Сургуулийн УТСОУХНУС-ийн
Улс төр судлалын тэнхим*

Нямаагийн ОТГОНБАЯР**

*Монгол Улс, Улаанбаатар, Монгол Улсын Их Сургуулийн УТСОУХНУС-ийн
Улс төр судлалын тэнхим***Received:** May 28, 2024**Revised:** October 10, 2024**Accepted:** November 04, 2024

Хураангуй: Улс төрийн үзэгдлийг судална гэдэг нарийн, төвөгтэй үйл явц юм. Албан ёсны төдийгүй зарим талаар албан бус, нуугдмал шинж чанартай харилцааг судлах, мөн чанарыг нь нээн илрүүлэх, түүгээр дамжуулан улс төрийн үзэгдлийг бүхэлд нь авч үзэх шаардлага гарна. Үүнтэй холбоотойгоор улс төрийн судалгаанд хэрэглэгдэх нэр томьёо, тодорхойлолтыг хэвшүүлэх асуудал онцгой ач холбогдолтой байдаг. Улс төрийн нэр томьёо, тодорхойлолтыг нэг мөр болгох зорилгоор МУИС-ийн Улс төр судлалын тэнхимээс санаачлан “Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг” нэрт бүтээл нийтлүүлсэн. Гэвч олон нэр томьёо тодорхойгүй хэвээр байна. Тэдгээрийн нэг нь улс төрийн патронаж гэх нэр томьёо болно.

Энэхүү өгүүлэлд орчин үеийн судалгаанд идэвхтэй хэрэглэгдэж буй улс төрийн патронаж хэмээх нэр томьёо, түүний тодорхойлолт, монгол хэлнээ уг нэр томьёог орчуулан хэрэглэж болох эсэх асуудлыг үгийн гарал, нэр томьёо судлалын үүднээс авч үзэж, тодорхой санал дэвшүүлэхийг оролдсон болно. Ингэхдээ гадаад, дотоодын судалгааны нэг сэдэвт зохиол, монгол хэлний тайлбар толиуд түүнчлэн зарим нэг эрдэмтний бүтээлд дүн шинжилгээ хийж гүйцэтгэсэн.

Түлхүүр үгс: Төрийн алба, томилгоо, патронаж, ивгээгч-үйлчлүүлэгчийн харилцаа, нэр томьёо

* © Ц.Батболд, 2024

✉ corresponding author Email: batbold_ts@num.edu.mn,  <https://orcid.org/0009-0004-6054-8649>

** © Н.Отгонбаяр, 2024

Email: otgonbayarnyamaa.n@gmail.com,  <https://orcid.org/0000-0002-5359-4311>

On the standardization and use of the term “political patronage”

BATBOLD Tserendash

Department of Political Science, School of Political
Science, International Relations, and Public Administration,
National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

OTGONBAYAR Nyamaa

Department of Political Science, School of
Political Science, International Relations, and
Public Administration, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

Abstract: *The study of political phenomena is a complex and multifaceted process. It requires not only an analysis of formal relationships but also an examination of informal and often concealed dynamics. By adopting this approach, political phenomena are understood in their entirety. In this context, the standardization of terminology and definitions in political science research becomes particularly important. To ensure consistency in political terminology, the Department of Political Science at the National University of Mongolia has launched the publication of the “Political Science Encyclopedia.” However, many terms remain ambiguous, including the term “political patronage.”*

This article aims to explore the term “political patronage,” which is commonly used in contemporary research, by providing a definition and evaluating whether it can be accurately translated into Mongolian. The article examines this issue from the perspectives of etymology and terminology studies and offers specific recommendations. It also analyzes both international and domestic monographs, Mongolian language dictionaries, and the works of various scholars.

Keywords: *civil service, appointment, patronage, patron-client relation, term.*

1. Удиртгал

Шинжлэх ухааны салбар бүрт нэр томъёог орчуулах, жигдлэх, хэвшүүлэх, хэрэглэх хэрэгцээ шаардлага байнга тулгарч байдаг. Үүний нэгэн адил Монгол Улс дахь улс төрийн судалгаанд сүүлийн жилүүдэд олон янзын нэр томъёо нэвтэрч, тэдгээрийг жигдлэх, хэвшүүлж орчуулах асуудал тулгам шинжтэй болж байна. Өөрөөр хэлбэл, нэр томъёоны олон талт байдал нь улс төрийн үзэгдэл, үйл явцыг судлан шинжлэхэд бэрхшээл үүсгэж байгааг дурдах байна. Улс төрийн шинжлэх ухааны нэр томъёог цэгцлэх, үндсэн утгыг тодорхойлох зорилгоор МУИС-ийн Улс төр судлалын тэнхим 2020 онд “Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг” нэрт бүтээл эрхлэн хэвлүүлсэн. Тус бүтээлд тус шинжлэх ухааны нийтдээ 842 нэр томъёог түүвэрлэн авч журамласан байна. Үүний зэрэгцээ нэр томъёо бүрд тодорхойлолт хийсэн (МУИС, 2020). Тодорхойлолт гэдэг нь “ухагдахууныг бусад холбогдох ухагдахуунаас ялгахын тулд шинжээр нь тодорхойлон бичсэн өгүүлбэр” (ISO 1087-1: 2019) юм. Энгийн үгээр хэлбэл, тодорхойлолт нь ухагдахуун, нэр томъёо хоёрын зуучийн үүрэг гүйцэтгэх бөгөөд

тухайн юм, үзэгдлийн онцлог шинжийг оновчтой, бүрэн гүйцэд илэрхийлсэн тайлбар хэмээн ойлгож болно. (Мөнхцэцэг, 2023: 58, 59). Гэвч улс төрийн шинжлэх ухаанд олон нэр томьёо тодорхой бус хэвээр үлдсэн. Тэдгээрийн нэг нь “улс төрийн патронаж” юм.

Өгүүллийн хүрээнд судлаачид улс төрийн *патронаж* хэмээх нэр томьёо, монгол хэлнээ хэрхэн ойлгож, орчуулан хэрэглэх тухайд тодорхой санал дэвшүүлсэн болно. Бүтцийн хувьд тус өгүүлэл нь удиртгал, судалгааны арга зүй, онолын судалгаа, дүгнэлт хэсгээс бүрдэл болно.

2. Судалгааны арга зүй

Судалгааны өгүүллийг бичихдээ герменевтик, харьцуулах, агуулгын шинжилгээний аргыг ашигласан болно. Өгүүллийн хүрээнд улс төрийн шинжлэх ухааны томоохон ойлголт, нэр томьёо болох патронаж харилцаа, түүний илрэн гарах хэлбэр, мөн чанар, монгол хэлнээ хэрхэн орчуулж, хэрэглэх асуудлыг бусад судлаачдын үзэл санаа, тэрчлэн үгийн гарал, үндсэн, салаа болон шилжсэн утга зэрэгтэй холбон авч үзэж судлахыг оролдсон болно.

3. Онолын судалгаа

Эртний Грекийн сэтгэгч Аристотель нэгэнтээ “Хүн бол уг мөн чанараараа улс төрийн амьтан мөн. Хэрэв хүмүүстэй хамтран амьдарч чаддаггүй эсвэл өөрийнхөө хэрэгцээг бүрэн хангачихсан, өөртэйгөө адил бусад хүмүүсээс тусдаа амьдарч чадах хэн нэгэн байгаа бол тэр нь адгуус юм уу аль эсвэл бурхан байж таарна. “Хүн бол нийгмийн зүг тэмүүлэх мөнхийн эрмэлзэлтэй” (Аристотель, 1983: 378) гэж тодорхойлон бичжээ. Нийгэм үүссэн цагаас эхлэн хүмүүс зохион байгуулалтын илүү боловсронгуй хэлбэрийг хайж, энэ явцдаа эзэн хаант, дарангуйлсан, язгууртны болон баячуудын, ард түмний болон зохион байгуулалтгүй олон түмний гэх мэт засаглалын янз бүрийн хэлбэрийг бий болгосон байдаг. Эртний Грекийн гүн ухаантан Платон ч энэ талаар өөрийн бүтээлд өгүүлсэн байдаг. (Жамбал, 2001). Гэвч нийгмийн харилцааны явцад үзэл бодол, итгэл үнэмшил нэгтнээ өмгөөлж хамгаалах, албан тушаалд дэвшүүлэх, улмаар тэдний хүчинд тулгуурлан хөгжих, зорилгодоо хүрэх гэсэн оролдлого тогтвортой байсаар иржээ.

Хэдийгээр *патронаж* гэсэн нэр томьёо харьцангуй сүүл үед бий болсон ч тухайн нэр томьёогоор илэрхийлэгдсэн үзэгдэл хүн төрөлхтний түүхийн нэн эрт үед үүсжээ. Эртний Египетэд патронаж харилцааг ямар нэгэн зүйлээр шалтаглан эрхшээлдээ байлгах гэсэн утга бүхий *vassalage* /хараат харилцаа/ хэмээх ойлголтоор дамжуулан илэрхийлж байжээ. (Вестбрук¹, 2005: 223). Бидний үед мэдэгдэж буй ийм харилцааны томоохон жишээ Птахотэптэй холбогдоно. Улсын тэргүүн түшмэл /жати/ 96 настай Птахотэп эзэн хаанаас албаны чөлөө мэдүүлэхийн зэрэгцээ хүүдээ албаа шилжүүлж, улс удирдахад тусыг бодож

¹ Westbrook

туршлагаа зааж сургах соёрхол хүсэмжилсэнд V угсааны Жэдкара Исэси фараон зөвшөөрчээ. Энэ үндсэн дээр “Птахотэпийн сургаал” нэрт бүтээл бичигдсэн нь өнөө бидний үе хүртэл хадгалагдан ирсэн байна (Голикова, Исаева, 2023: 10-12).

Эртний Вавилоны Хаммурабийн засагчлах бичигт патронаж харилцааг шан, харамж горилогч гэсэн утга бүхий *šulmānu* буюу *kadrû* (Вестбрүүк, 2005: 219), харин Библийн сударт үнэнч байх гэсэн утга бүхий *hesed*² (פֶּסֶד) хэмээх нэр томьёо (Вестбрүүк, 2005: 215)-гоор дамжуулан илэрхийлсэн байдаг. Ерөнхий утга нь барьцаалагдсан шан, харамж гэсэн санааг илэрхийлнэ. Уг харилцааг нэг талаас, эд баялаг, эрх мэдэл бүхий этгээд, нөгөө талаас, шаардлагатай улс төрийн дэмжлэг, туслалцаа үзүүлж, хариуд нь эд баялаг горилох этгээд гэсэн хоёр субъект төлөөлж байсан талаар хожмын судлаачид бүтээлдээ онцолсон байдаг (Финкелштейн³, 1952: 77-80; Мэтьюс⁴ & Бенжамин⁵, 1993).

Эртний Ромд Египетээр дамжин уг харилцаа хөгжсөн бөгөөд *патронаж* хэмээх нэр томьёогоор илэрхийлэх болжээ. Патронаж хэмээх ухагдахуун Ромын эзэн хаан Гай Октавигийн үед амьдарч байсан язгууртан Гай Цильни Мэцэнатын үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн. Тэрээр эзэн хааны даалгаврыг биелүүлэхийн зэрэгцээ урлаг, соёлын бүтээлд дэмжлэг үзүүлдэг байсан нь *патронаж* хэмээн нэрлэгдэх болжээ (Zadoia & Syzonenko, 2021: 18). Хожим нийгмийн үндсэн давхарга болох патриц, плебей нарын хоорондын өвөрмөц, харилцан ашигтай харилцааг уг нэр томьёогоор дамжуулан илэрхийлсэн. Өөрөөр хэлбэл, эд баялаг, нэр хүнд, эрх мэдэл бүхий патриц, улс төрийн дэмжлэг, туслалцаа үзүүлж, засаглалын хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хангах, хариуд нь эд материалын дэмжлэг эрэлхийлэх плебей нар уг харилцааны агуулгыг тодорхойлж байжээ. (Quinn, 1982: 117).

Үгийн гарал, утгын талаас авч үзвэл, *патронаж* гэдэг нь хожуу латин хэлний *patronus*, *patroun* буюу ивээгч, хамгаалагч, эртний франц хэлний *patron* буюу ивээгч, хамгаалагч, ариун ивээгч гэсэн утга бүхий үгийн үүсгэл болно. (Төгөлдөр, 2022: 729). “Ашиг тусаа үзүүлэгч ариун гэгээнтэн, авран хамгаалагч”, “ажил, үйлсийг ивээн тэтгэгч нэгэн” зэрэг утгыг илэрхийлж байснаа 1769 оноос “бараа, ажил, үйлчилгээ үзүүлэгч, төрийн албанд ажил хуваарилах эрх мэдэлтэн” гэсэн санааг агуулах болсон. Өөрөөр хэлбэл, шашны, нийгмийн утга агуулгатай байснаа улс төрийн болон эдийн засгийн утга санаа илэрхийлэх болсон. Дундад зууны үед католик сүм хийдэд санваартан томилох эрхийг *патронаж* хэмээн нэрлэдэг байв. Англид хатан хаан Виктори, эзэн хаан Эдуард нарын үеэс төрийн албанд патронаж нэлээд хүчээ авсан байдаг. (Куинн⁶, 1982).

Шинжлэх ухаанд патронаж хэмээх нэр томьёо дараах утга санааг илэрхийлж байна. Үүнд:

² Үнэнч байх гэсэн утга бүхий *hesed* хэмээх ойлголтыг Библи сударт нийтдээ 250 удаа ашигласан байдаг.

³ Finkelstein, J

⁴ Matthews, W

⁵ Benjamin, D

⁶ Quinn, K

1. Патрон буюу ивээгч, хамгаалагчийн нөлөөлөл буюу тусламж, дэмжлэг;
2. Эрхэм дээд хүний үйл;
3. Патрон буюу ивээгчийн үйл ажиллагаа, бизнес;
4. Төрийн албан тушаалд улс төрийн хэмжүүрийг удирдлага болгож хэн нэгнийг томилох эрх (Доналд⁷, 1903: 359) зэрэг болно.

Нэр томъёоны хувьд ивээгч, хамгаалагч гэсэн утгыг илэрхийлэх ч улс төрийн судалгаанд харилцан ашигтай байхыг гол зарчмаа болгосон эрх тэгш бус хоёр этгээдийн дунд үүсэх нэгэн төрлийн өвөрмөц харилцааг илэрхийлдэг байна. ХБНГУ-ын Конрад-Аденауэр Сангаас санаачлан санхүүжүүлж Удирдлагын Академи, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимтэй хамтран хэрэгжүүлж буй судалгааны тайлангуудад тэрчлэн зарим нэг судлаачийн бүтээлд патронаж гэдгийг монгол хэлнээ “ивээл, хамгааллын бодлого”, “улс төрийн ивээлийн томилгоо” (Зүмбэрэлхам, 2020: 72; Конрад Аденауэр сан, 2021: 106) хэмээн орчуулсан байна.

Ивээл, хамгаалал гэдгийг монгол хэлний тайлбар толиудад дараах байдлаар авч үзжээ. Үүнд:

Эрдэмтэн Я. Цэвэл (1966) ивээх гэдгийг “энэрэх, өршөөх, тэтгэн хамгаалах, ивээж өршөөх, хайрлаж ивээх”, харин хамгаалах гэдгийг “сэргийлэн сахих, харгалзан сахих, өмөөрөн хаацайлах”, эдгээр үйлийг эрхлэгчийг “ивээгч, хамгаалагч” гэж тус тус тайлсан байна. (1966: 299, 655).

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн “Монгол хэлний тайлбар толь”-д ивээх гэдгийг “ач буян, энэрэл өршөөл, хайр тэтгэмж хүртээх”, хамгаалах гэдгийг “учирч болох элдэв аюул ослоос сэргийлэн хөнөөл учруулахгүйн төлөө сахин хамгаалах, өвчин хүрэхээс сэргийлэх, хайрлаж ариглах, гамнах, өмөөрөх, хаацайлах”, уг үйл эрхлэгчийг “ивээгч, хамгаалагч” гэж тайлбарласан байна. (Баярсайхан, Янжиндолгор, 2011: 610, 1394).

Эндээс үзэхэд, *патронаж* хэмээх нэр томъёо нь хариу нэхдэггүй үйл болох “ивээх, хамгаалах” гэсэн утгыг илэрхийлэх боловч хэрэглээний хувьд оролцогч талууд нэг нэгнийхээ үйлээс ашиг тус горилсон харилцааг ойлгодог байна. Нөгөө талаас, зөвхөн нэг тал давамгайлсан бус, хоёр талын (патрон, клиентийн) харилцан ашигтай харилцаа юм. Эдгээр нөхцөлийг тооцвол монгол хэлнээ ивээл, хамгааллын бодлого, улс төрийн ивээлийн томилгоо бус, олон улсад тогтсон нэршлээр ашиглах нь зүйтэй гэж үзсэн байна.

Судалгааны хүрээнд патронажийн тухай ойлголт бие даасан судлагдахуун болж хөгжсөн нь нэлээд хожуу буюу XX зууны 50, 60-аад оны үетэй холбогдоно. Антропологийн чиглэлийн судалгаануудад анх нэвтэрч (Гилев, 2016: 8) улс төрийн үзэгдэл, үйл явцыг тайлбарлах ойлголт болж өргөжсөн байна. Дээрхээс гадна, орчин үеийн улс төрийн шинжлэх ухаанд *патронаж* хэмээх ухагдахуун нэр томъёоны хувьд нэг мөр болж чадаагүй байдал ажиглагдаж байна. Нэршлийн хувьд “патронаж” /patronage/, “улс төрийн патронаж” /political patronage/, “намын

⁷ Donald, J

патронаж” /party patronage/, “патрон-клиентийн харилцаа” /patron-client relations/ гэх мэт олон нэр томьёог адил утгаар ойлгож, хэрэглэж байгааг дурдах байна (Zarembo, 2016). Эдгээрийг нэг бүрчлэн авч үзье.

Нэгдүгээрт, юуны түрүүнд, *патронаж* гэх нэр томьёо асуудлыг илүү өргөн хүрээнд авч үздэг онцлогтой. Ингэхдээ ивээн тэтгэх гэсэн утгаар голчлон хэрэглэдэг байна. Энэ утгаар авч үзвэл өндөр настны, хүүхдийн, эмэгтэйчүүдийн, нийгмийн эмзэг бүлгийн патронажийн тухай ярьж болох байна. Өөрөөр хэлбэл, илүү өргөн утга, агуулга бүхий нэр томьёо учир судалгааны хүрээнд ашиглахад оновчтой бус гэж үзлээ.

Хоёрдугаарт, патронаж харилцаанд улс төрийн намуудаас гадна хувь улс төрчид ивээн тэтгэгчээр оролцох боломжтой байдаг. Иймд намын патронаж гэсэн явцуу утгаар хэрэглэх нь судалж буй үзэгдлээ боломжит хүрээнд авч үзэхэд хүндрэл учруулж болзошгүй гэж үзэж байна.

Гуравдугаарт, патрон-клиентийн харилцаа гэсэн нэр томьёо нь төрийн албан дахь мөн төрлийн харилцааг бүрэн илэрхийлж чаддаггүй. Учир нь бидний авч үзэж буй харилцаанаас гадна клиентелизм, түүний хэлбэр болох протекционизм, непотизм, патернализм, фаворитизм, авлига гэх мэт албан бус шинжтэй илэрдэг олон төрлийн харилцаа патрон-клиентийн хоёр талт шинж чанарыг өөртөө агуулдаг. Ийм учраас патрон-клиентийн харилцаа хэмээх нэр томьёог судалгааны үндсэн чиглэл, зорилгод оновчтой бус гэсэн санааг илэрхийлж байна. /Хүснэгт 1/


Хүснэгт 1. Улс төрийн патронаж, клиентелизм ба авлига хэмээх ухагдахууны ялгаа

	Улс төрийн патронаж (Political Patronage)	Клиентелизм (Clientelism)	Авлига (Corruption)
Төрийн нөөц	Төрийн байгууллагын албан тушаал	Төрийн албан тушаал, зээл тусламж, татварын хөнгөлөлт, эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэт	Төрийн бодлого, шийдвэр
Намын зорилго	Төрийн байгууллагад хяналт тогтоох: Намын бодлогод захируулах	Сонгогчдоос дэмжлэг олох	Санхүүгийн нөөцийг үр дүнтэй ашиглах
Ашиг тусыг нь хүртэгчид	Хэн ч байж болно	Намын идэвхтэн, дэмжигчид	Пүүс, компани, үйлдвэрийн газар
Хуульд нийцсэн байдал	Хууль ёсны болон хууль бус хэлбэрээр	Хууль ёсны болон хууль бус хэлбэрээр	Хууль бус хэлбэрээр
Шалгуур	Бидний төлөө ажиллаж чадах уу?	Бидний төлөө сонголт хийж чадах уу?	Бидэнд илүү ихийг өгч чадах уу?

Эх сурвалж: (Kopecky, Scherlis ба Spirova, 2008: 8)

Манай улсад судлаачдын нэг сэдэвт болон орчуулгын бүтээлүүдэд улс төрийн *патронаж* (*political patronage*), *клиентелизм* (*clientelism*) гэсэн нэр томъёог ижил утгаар хэрэглэж буй хандлага байна. Энэ нь тухайн чиглэлд судалгаа харьцангуй бага хийгдэж байгаатай холбоотой тул цаашид лавшруулан судлах шаардлага буйг илтгэнэ. Ялангуяа Михал Климагийн бүтээл Монгол хэлнээ орчуулагдан гарсны дараа нэлээд хүчтэй болсон. Тэрээр клиентелизмийг “*хоёр болон олон хүнийг хамарсан найз нөхөд, хамаатан садны онцгой харилцаа, холбоо бөгөөд их төлөв тодорхой зорилгод чиглэсэн байх ба нийгэм, эдийн засгийн хувьд дээгүүр зиндааны нэг этгээд (патрон) нь доогуур зиндааны нөгөөдөө (клиент) өөрийн нэр нөлөө, боломж бололцоог ашиглан хангамж, хамгаалалт үзүүлж байхад клиент нь мөн хариуд нь ивээн тэтгэгчдээ өөрийн биеэр үйлчлэх зэргээр ерөнхий дэмжлэг, тусалцаа үзүүлдэг үзэгдэл мөн*” (Клима, 2017: 7) гэж тодорхойлжээ. Гэхдээ улс төрийн патронаж, клиентелизм хэмээх хоёр ойлголт харилцан ялгаатай гэдгийг дурдах байна.

Зураг 1. Клиентелизм, түүний онцлог шинж




Эх сурвалж: Судлаачдын боловсруулсан.

Судалгааны бүтээлүүдэд клиентелизм гэдгийг үйлчлэгчийн (их төлөв эдгээрийг клиент гэж нэрлэдэг) зүгээс үнэнч байдлыг чухалчлах, хариуд нь ивээгчийн (ихэвчлэн эдгээрийг патрон гэж нэрлэдэг) зүгээс зан үйл, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчин тэдэнд байгууллагын нөөцөд нэвтрэх, өмгөөлөл, хамгаалал хүртэх боломж олгодог нууц, далд хэлбэрийн босоо харилцаа бүхий удирдлага-зохион байгуулалтын үзэгдэл мөн (Харитонов, 2013: 32) гэж үзсэн байдаг.

Харин улс төрийн патронаж харилцаанд илүү тодорхой, өөр шинж давамгайлдаг. Юуны түрүүнд, зөвхөн төрийн албан тушаал хуваарилахтай холбоотойгоор үүсэх харилцаа болно. Ингэхдээ улс төрийн үнэнч байдлыг гол

шалгуур болгодог. Гэхдээ улс төрийн хувьд үнэнч байна гэдэг нь үйлчлэгч заавал ч үгүй эрх баригч намын гишүүн байх юм уу, сонгуульд тэдний төлөө саналаа өгөх ёстой гэсэн үг биш юм. Өөрөөр хэлбэл, намын гишүүн байснаар юм уу сонгуулийн үед санал өгснөөр үнэнч байдал тодорхойлогддоггүй.

Зураг 2. Клиентелизм болон улс төрийн патронажийн ялгаа



Эх сурвалж: (Vitis, 2016: 20)

Судлаачдын зүгээс судалгааны хүрээнд *нэгдүгээрт*, улс төрийн субьектийн санаачилгаар бий болж хэрэгждэг, *хоёрдугаарт*, харилцаанд оролцогчдын нэг тал нь ямагт улс төрийн субьект байдаг, *гуравдугаарт*, улс төрийн бүх субьектийг хамруулан судлах боломж олгодог, *дөрөвдүгээрт*, уг үйл явц хэрэгжсэнээр улс төрийн тодорхой эрх ашиг хангагддаг гэж үзсэн тул “улс төрийн патронаж” /political patronage/ гэсэн нэр томьёог хэрэглэх нь оновчтой гэсэн санааг дэвшүүлж байна.

Улс төрийн патронаж гэх нэр томьёоны талаар олон янзын тодорхойлолт байх ч нийтлэг шинжид тулгуурлан судлаачдын зүгээс дараах байдлаар тодорхойлсон болно. “Хуульд нийцсэн, үгүйгээс үл хамааран улс төрийн субьектүүдийн зүгээс гишүүн, дэмжигчдээ мэдлэг чадвар, мэргэшил, туршлага шаардах төрийн албан тушаалд үнэнч байдлыг шалгуур болгон томилох, юм уу уг шалгуурыг үндэслэн төрийн албан хаагчдыг албан тушаалаас халах, чөлөөлөх үйл явцтай хамаарал бүхий патрон, клиентийн хоёр талт харилцаа мөн” (Төмөр, Отгонбаяр, 2023: 72; Батболд, Отгонбаяр, 2023: 98, 99).

4. Дүгнэлт

Аливаа судалгаанд хэрэглэж буй нэр томьёо, түүний тодорхойлолтыг нэг мөр болгох асуудал онцгой ач холбогдолтой. Учир нь нэгдсэн нэр томьёо,

тодорхойлолт бий болгохгүйгээр судалгаа үр дүнд хүрдэггүй. Тиймээс бид дараах санааг тус өгүүллийн дүгнэлт болгож байна. Үүнд:

1. Улс төрийн судалгаанд албан бус харилцааны нэг илрэл болох патронаж үзэгдлийг судлах явдал онцгой чухал болсон.
2. Гэвч уг үзэгдлийг илэрхийлсэн нэр томъёо, тодорхойлолтын маргаантай асуудал байсаар байна. Тухайлбал, “патронаж” /patronage/, “улс төрийн патронаж” /political patronage/, “намын патронаж” /party patronage/, “патрон-клиэнтийн харилцаа” /patron-client relations/ гэх мэт олон нэр томъёог адил утгаар хэрэглэж байна. Тэрчилэн тодорхойлолтын хувьд ч харилцан адилгүй байр суурь хадгалагдсан хэвээр байна.
3. Тиймээс монгол хэлнээ *улс төрийн патронаж* гэх нэр томъёог үгийн сан, нэр томъёо судлалын талаас авч үзэх асуудал өнөөдрийг хүртэл хариулт эрэлхийлсэн хэвээр байна.
4. Хэдийгээр уг гарлын хувьд хариу нэхдэггүй тус болох ивээл, хамгаалал гэсэн утгыг илэрхийлэх боловч ухагдахууны хувьд харилцан ашигтай байх зарчмыг гол болгосон, эрх тэгш бус хоёр болон түүнээс дээш этгээдийн дунд үүсэх харилцааг “улс төрийн патронаж” хэмээн нэрлэдэг байна. Үүнээс үзэхэд монгол хэлнээ ивгээл, хамгааллын томилгоо хэмээн орчуулж хэрэглэх нь оновчтой бус бөгөөд олон улсад тогтсон нэрлэлтээр “улс төрийн патронаж” хэмээн орчуулж, хэрэглэх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.
5. Улс төрийн патронажийг янз бүрийн тодорхойлолт байх боловч хуульд нийцсэн, үгүйгээс үл хамааран улс төрийн субъектүүдийн зүгээс гишүүн, дэмжигчдээ мэдлэг чадвар, мэргэшил, туршлага шаардах төрийн албан тушаалд үнэнч байдлыг шалгуур болгон томилох, юм уу уг шалгуурыг үндэслэн төрийн албан хаагчдыг албан тушаалаас халах, чөлөөлөх үйл явцтай хамаарал бүхий патрон, клиэнтийн хоёр талт харилцаа мөн хэмээн ойлгох нь оновчтой гэж үзсэн болно.

Талархал

Тус өгүүлэл нь “Монгол Улс дахь төрийн албаны патронаж томилгоо: Шалтгаан, өнөөгийн байдал, шийдвэрлэх боломжууд” нэрт улс төрийн шинжлэх ухааны докторын зэрэг горилох судалгааны хүрээнд бичигдсэн болно. Эрдэм шинжилгээний өгүүллийг бичихэд мэргэжил, онол-арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч, чиглүүлж ажилласан МУИС-ийн дэд профессор, доктор (Ph.D), Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч Д. Ундрах, ШУТИС-ийн профессор, доктор (Ph.D) Я. Төгөлдөр, Этүгэн Их Сургуулийн профессор, доктор (Ph.D), гавьяат эдийн засагч О. Лхагварэнцэн нарт талархал илэрхийлье.


Ном зүй

- Аристотель.** (1983). *Политика*. Перевод с древнегреч. С. Жебелева. Сочинения: В 4 т. Москва: Т. 4. «Мысль». [Aristotle. Politics. Moscow: Thinking Press, 1983.]
- Батболд, Ц., Отгонбаяр, Н.** (2023). Патронажийн тухай ойлголт, улс төрийн хандлага. *Studia Philosophiae Et Juris, XXXVIII*. [Batbold, Ts., Otgonbayar, N. *Patronagiin tuhai oilgolt, uls türiin handlaga* [Concept of Patronage and Political Approach.] *Studia Philosophiae Et Juris*, 2023, XXXVIII]
- Баярсайхан, Б., Янжиндолгор, А.** (Хянд.) (2011). *Монгол хэлний тайлбар толь*. Улаанбаатар хот: АДМОН ХХК. [Bayarsaikhan, B., Yanjindolgor, A. *Mongol helnii tailbar toli* [Mongolian Explanatory Dictionary.] Ulaanbaatar: Admon Press, 2011]
- Гилев, А.** (2016). Введение. Черные кошки в темных комнатах: Исследования политического патронажа в общественных и гуманитарных науках. In *Патрон-клиентские отношения в истории и современности: Хрестоматия* (pp. 6-40). Москва: РОССПЭН. [Gilev, A. Introduction. Black Cats in Dark Rooms: Research on Political Patronage in the Social and Human Sciences. [in book 'Patron-Client Relations in History and Modernity: A Reader'.] Moscow: ROSSPEN, 2016.]
- Голикова, А., & Исаева, А (Ред.)** (2023). *История политических учений. Учебник для академического бакалавриата*. Москва: Юрайт. [Golikov, A., Isaev, A. History of Political Theories. A Textbook for Academic Bachelor's Degree Programs. Moscow: Yurait, 2023.]
- Жамбал, А.** (2001). *Улс төрийн сургаалиудын түүх. Нэгдүгээр дэвтэр*. Улаанбаатар хот: Бемби сан. [Jambal, A. *Uls türiin surgaaliudiin tüükh*. Negdügeer devter [History of Political Theories. Volume One]. Ulaanbaatar: Bembi San Press, 2001.]
- Зүмбэрэлхам, Д.** (2020). Чадахуйн зарчим ба төрийн албаны хууль тогтоомжийн шинэтгэл. *Төрийн албаны шинэтгэл: Гарын авлага* (71-78). [Zumberellham, D. The Principle of Merit and the Legislative Reform of Public Service. *Türiin albanii shinetgel: Gariin avlaga* 2020, 71-78]
- Клима, М.** (2017). *Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу: Далд бизнес улс төрийн намуудыг хувьчлан колоничилсон нь*. (Р. Батсайхан, П. Цэнгүүн, Д. Амартүвшин, Хян., & Ж. Сайханзаяа, Орч.) Улаанбаатар: Сэлэнгэ Пресс. [Klima, M. *Totalitor deglemees gajuudsan ardchilal ruu: Dald biznes uls töriin namuudiig huvichlan kolonchilson ni* [From Totalitarian Regime to Distorted Democracy: How Hidden Businesses Have Privatized and Colonized Political Parties]. Ulaanbaatar: Selenge Press, 2017.]
- Конрад Аденауэр сан.** (2021). *Монголын ардчилал: Төлөөллийн ардчиллын сорилт ба шууд ардчиллын боломж*. (Ш. Батсүх, Хян.) Судалгааны тайлан, Улаанбаатар [Konrad Adenauer Foundation. *Mongoliin ardchilal: Tülüülliin ardchlliin sorilt ba bolomj* [Democracy in Mongolia: The Challenges of Representative Democracy and the Opportunities for Direct Democracy. Report] Ulaanbaatar: 2021.]
- МУИС.** (2020). *Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг*. (Ж. Төртөгтох, Хян.) Улаанбаатар хот: Адмон Принт ХХК. [NUM. *Uls turiin shinjleh uhaanii neverterhii toli bichig*. [Political Science Encyclopedia.] Ulaanbaatar: Admon Print LLC. 2020.]

- Төгөлдөр, Я.** (2022). *Патронаж/ Ивээлд авах үзэл (Patronage)*. Конрад- Аденауэр Сан, Ш. Батсүх, Н. Бурмаа, Я. Долгоржав, & С. Ганзаяа (Хянд.)-Д, *Захиргааны шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь* (237). Анхны хэвлэл, Улаанбаатар хот. [Tuguldur, Ya. *Patronag/Iveeld avah üzel Patronage*. [in book ‘Glossary of Administrative Science Terminology] Ulaanbaatar: 2022]
- Мөнхцэцэг, Н.** (2023). Нэр томъёоны тодорхойлолтыг стандарт шаардлагын үүднээс задлан шинжлэх нь. *Хэрэглээний хэл шинжлэл сэтгүүл, Том VIII*. [Munkhtsetseg, N. Analyzing Definitions of Terms in Terms of Standard Requirements. *Mongolian Journal of Applied linguistics*, 2023, TomVIII.]
- Төмөр, Т., Отгонбаяр, Н.** (2023). Патронаж томилгооны талаарх ойлголт, онолын хандлагууд. *Төрийн удирдлага онол, арга зүйн сэтгүүл, №22*. [Tumur, T., Otgonbayar, N. Concept of Patronage Appointments and Theoretical Approaches. *Mongolian Journal of Public Management*, 2023, No22.]
- Харитонов, В.** (2013). *Клиентелизм в государственной службе: причины и пути ограничения*. Диссертация на соискание ученой степени кандидата социологических наук, Москва: Московский Государственный Университет имени М. В. Ломоносова. [Kharitonova, V. Clientelism in Public Service: Causes and Ways to Limit It. Moscow: Moscow State University. 2013.]
- Цэвэл, Я.** (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. (Х. Лувсанбалдан, Хян.) Улаанбаатар хот: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. [Tsevel, Ya. *Mongol helnii товч тайлбар толь* [Mongolian concise dictionary]. Ulaanbaatar: State Press Affairs Committee. 1966.]
- Donald, J. (Ed.)** (1903). *Chamber's etymological Dictionary of English Language*. London and Edinburgh: W. R. Chambers.
- Finkelstein, J.** (1952). The Middle Assyrian šulmānu-Texts. *Journal of the American Oriental Society* (72).
- Matthews, W., & Benjamin, D.** (1993). *Social World of Ancient Israel 1250-587 BCE*. Peabody, MA: Hendrickson.
- Petr Kopecký, Peter Mair, Maria Spirova** (2012). *Party Patronage and Party Government in European Democracies*. Oxford: Oxford University Press.
- Quinn, K.** (1982). Poet and Audience in the Augustan Age. *Aufstieg und Niedergang der römischen Welt, Vol. 30* (No 1).
- Vitis, M.** (2016). *Party patronage in parliament: The Italian experience*. Submitted to the Department of Political Science in partial fulfillment of the requirements for the degree of Doctor of Philosophy in Political Science, Rome: The LUISS “Guido Carli” University.
- Westbrook, R.** (2005). Patronage in the Ancient Near East. *Journal of Economic and Social History of the Orient, Vol. 48* (No 2).
- Zadoia, A., & Syzonenko, I** (2021). The role of patronage in popularizing the work of Stanislav Zhukovsky. *Science and Education a New Dimension. Humanities and Social Sciences, IX* (46).

Zaremba, A. (2016). Partinio patronažo konceptualizavimas. *Public Policy and Administration*, Vol. 15 (No 3).

ISO 1087-1: 2019. Terminology Work and Terminology Science



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.